

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил	5
2.2. Физик-газарзүйн нөхцөл	5
2.3. УУР АМЬСГАЛ	7
2.4. АГААРЫН ЧАНАР	10
2.5. ГАДАРГЫН УС	11
2.6. ГАЗРЫН ДООРХ УС	12
2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ	13
2.8. УРГАМЛАН НӨМРӨГ	15
2.9. АМЬТНЫ АЙМАГ	16
2.10. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ	17
2.11. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ	19
2.12. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ	20
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	22
3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл	22
3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.3. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	23
3.4. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	23
3.5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл	23
3.6. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	23
3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	24
БҮЛЭГ-4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
4.1. Тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	27
4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	28
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
4.5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32
4.7. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
Хүснэгт 2. Төсөл хэрэгжүүлэх талбайн булангийн цэгүүдийн солбилцол	3
Хүснэгт 3. Өмнөговь аймгийн газар нутгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлал	6
Хүснэгт 4. Өмнөговь аймгийн хур тунадасны хэмжээ	8
Хүснэгт 5. Агаарын чанарын хэмжилтийн дүн	10
Хүснэгт 6. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ	14
Хүснэгт 7. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд	14
Хүснэгт 8. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж	15
Хүснэгт 9. Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал	15

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
Хүснэгт 11. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө.....	28
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
Хүснэгт 15. Таван жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн зураг	4
Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг	5
Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг (Ш.Цэгмид, 1969 он)	6
Зураг 4. Агаарын дундаж температурын явц, °C	7
Зураг 5. Агаарын дундаж температурын жилийн явц, °C	8
Зураг 6. Хур тунадасны жилийн явц, мм-р болон жилд эзлэх хувь	9
Зураг 7. Жилийн нийлбэр тунадасны хуваарилалт, өөрчлөлтийн хандлага.....	9
Зураг 8. Салхины дундаж хурдны явц	10
Зураг 9. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийсэн байдал.....	11
Зураг 10. Төслийн талбай орчмын усны сав газар болон гадаргын усны тархацын зураг.	12
Зураг 11. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг	14
Зураг 12. Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөгийн хэв шинж	16
Зураг 13. Төсөл хэрэгжих талбайн орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	18
Зураг 14. Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	19
Зураг 15. Ханбогд сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын байршил	20
Зураг 16. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс	22
Зураг 17. ОХШХ хэрэгжүүлэх цэгийн байршлын зураг	34

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нүүрс ачиж буулгах гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт хилээс хойш 20 орчим км-т аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 75 км зайд 40 га талбайг хамран байрлаж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	ААН	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Газрын байршил
1	“Пушинмон” ХХК	2889625	1111014141	Өмнөговь аймаг, Ханбогд сум, Хайрхан баг, Цагаан хад суурьшлын бүс

Хүснэгт 2. Төсөл хэрэгжүүлэх талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	B	L	Талбайн хэмжээ, га
1	42° 36'07.6"	107° 31'25.6"	40
2	42° 36'21.4"	107° 31'12.0"	
3	42° 36'29.9"	107° 31'27.2"	
4	42° 36'37.0"	107° 31'38.6"	
5	42° 36'23.6"	107° 31'52.0"	





Зураг 1. Төслийн талбайн зураг

Хүчин чадал- “Пүшинмон” ХХК нь өөрийн боловсон хүчинтэй, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулах бааз суурь сайтай, засвар үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй, нүүрс ачилт буулгалтын талбайд 750 м урт, 10 м өндөр салхины хаалт хашаатай, хоногт 150-200 машин нүүрс буулгаж ачих, гадна талбайд 260 машин зогсох бүрэн хүчин чадалтай, ZTE маркийн ачигч ковш 4 ш, ХК3190-А9 загвар бүхий авто жин пүүлэлт 2 ш, Dell маркийн суурин компьютер 2 ш, принтер 3 ш зэрэг тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нүүрс ачиж буулгах талбайн хэмжээ 12 га бөгөөд нийт 1,000,000 тн нүүрс нөөцлөх боломжтой. Хоногт 150-200 машин нүүрс буулгаж ачих гадна талбайд 260 машин зогсох хүчин чадалтай.

Усан хангамж - Тус төслийн хүрээнд 28 ажиллагсад байнга ажиллах ба нэг ажилчны хоногийн усны хэрэгцээг 20* л гэж үзвэл 560 л ус хоногт, жилд /360 хоног/ 201.6 м³ хэрэгцээтэй байна. (* - БОНХАЖ -ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“ Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангадаг гэр хороолол – 20 л/хоног/хүн)


Ундны усыг савлагаатай цэвэр усаар хангадаг бол тоосжилтыг бууруулах болон бусад усыг төслийн талбайгаас 21.7 км -ийн зайд / 42°46'56.00"N - 107°24'12.00"E/ байрлах Иргэн Б.Баярцэнгэлийн эзэмшлийн 2.4 л/с ундрагатай гүний худгийн уснаас зөөвөрлөн авч, 2 тн цэвэр усны нөөцийн саванд түр хадгалан ашиглаж байна.

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НЙИГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил

"Пушинмон" ХХК -ийн нүүрс ачиж буулгах, гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт улсын хилээс хойш 20 гаруй км -т Цагаан хадын худгаас баруун хойш 3.5 км–т 40 га газар байрлана. Тус талбай нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км зайд байрлана.


Ханбогд сум нь урд талаараа БНХАУ-тай хил залгаа Гашуун сухайт боомттой, баруун талаараа Баян-Овоо сум, хойд талаараа Манлай сум, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залгаа оршино.



Зураг 2. Төслийн талбайн байршилын зураг

2.2. ФИЗИК-ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

Өмнөговь аймаг нь 165.0 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийн хэмжээгээрээ Монгол улсдаа хамгийн томд ордог аймаг юм. Аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны Байгалийн бүс бүслүүрийн ангиллаар Говийн болон Цөлийн бүсэд багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтана уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.



Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг (Ш.Цэгмид, 1969 он)

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамалшил, амьтны аймгийн хам бүрдэл, тэдгээрийн хоорондын ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцөлүүдээр нь 3 муж, 5 тойрог болгон мужилсан байдаг.

Хүснэгт 3. Өмнөговь аймгийн газар нутгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлал

№	Мужийн нэр	Тойргийн нэр	Талбай, га
1	Говийн Алтайн уулсын муж	Их, Бага Богдын уулсын тойрог (Г-5)	285362.4
		Гурвансайхан уулсын тойрог (Г-6)	2237586.4
2	Алтайн өвөр говийн цөлийн муж	Алтайн өвөр говийн тойрог (Г-8)	4660120.5
3	Дорнод говийн цөлөрхөг муж	Дорнод говийн хойд хэсгийн тойрог (Г-9)	3263476.8
		Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)	6091501.0
-	Нийт		16538047.0

“Пушинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн талбай буюу Ханбогд сум нь Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)-т хамаарч байна.

Ханбогд сум нь газарзүйн байршлын хувьд Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Тухайн сум нь говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1266 м) зэрэг уулс орно.

2.3. УУР АМЬСГАЛ

Өмнөговь аймаг нь байгаль цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус, салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрдэг.

Өмнөговь аймгийн нутагт уул нуруу, говь хонхор, газрын гадаргын хэв шинж олон янз учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь хэд хэдэн муж болж хуваагдах онцлогтой байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын 3 мужид хувааж болж байна.


Үүнд:

- Хуурай сэрүүвтэр муж
- Хуурай дулаавтар муж
- Нэн хуурай дулаан муж

Нарны гийгүүлэлт: Манай орны нутгаар жилд дунджаар нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа 2800-3600 цагийн хооронд хэлбэлзэж байдаг ба нийлбэр цацрагийн хэмжээ жилд 5237.5-6285 мДж/м² байдаг.

Ханбогд сумын орчмоор агаарын температурын ОЖД нь 7.9⁰С бөгөөд сүүлийн таван жилийн дундаж утга 8.5⁰С, температурын хандлагын өөрчлөлтийг боловсруулж үзэхэд: сүүлийн жилүүдэд агаарын дундаж темпеартурын утга ОЖД-аас 0.6⁰С-р дулаарсан ажиглагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хандлага нь жилд дунджаар -0.0253⁰С-аар буюу алгуур өөрчлөлт ажиглагдаж байна.


Ханбогд сумын хувьд зундаа 40⁰С хүртэл халж, өвөлдөө -15-25⁰С хүрч хүйтэрдэг байгалийн эрс тэс уур амьсгалтай. Монгол Улсын хамгийн дулаан цэгт тооцогддог газар нутаг юм.



Зураг 4. Агаарын дундаж температурын явц, ⁰С

Ханбогд сумын агаарын дундаж температурын жилийн явцыг харахад -10.5-25.7⁰С хооронд хэлбэлзэж байна. Жилийн хамгийн дулаан сарууд 6,7,8-р саруудад ажиглагдах бөгөөд 8 болон 10-р саруудад бусад бүх саруудад олон жилийн дундажаас 0.1-2.5⁰С-р дулаан гарч байгаа нь сүүлийн жилүүдэд уур амьсгалын

өөрчлөлтийн нөлөө Ханбогд сумын нутгаар маш хурдцтай явагдаж байгаа нь харагдаж байна.



Зураг 5. Агаарын дундаж температурын жилийн явц, °C

Хур тунадас: Өмнөговь аймгийн хур тунадасны хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Өмнөговь аймгийн хур тунадасны хэмжээ


№	Он / сар	1 сар	7 сар
1	2018	7.2	136.1
2	2019	0.2	17.1
3	2020	0.7	15.8
4	2021	0.6	176.7
5	2022	0	16.5

Дээрх хүснэгтээс үзэхэд Өмнөговь аймагт өвлийн улиралд тунадас бага унаж, дулааны улиралд хур борооны хэлбэрээр хур тунадас их унаж байна. Сүүлийн 5 жилийн 1 сарын байдлаар 2018 онд хамгийн их 2022 онд хамгийн бага, харин 7 сарын байдлаар 2020 онд хамгийн бага 2021 онд хамгийн их хур тунадас орсон байна.

Ханбогд сумын орчмоор ОЖ-ийн дунджаар жилдээ 109.2 мм хур тунадас ордог. Сүүлийн зургаан жилийн дунджаар 132.5 мм хур тунадас орсон байгаа нь ОЖ-ийн дунджаас 23.3 мм-орчмоор ахиу хур бороо сүүлийн жилүүдэд орсон байна. Сүүлийн зургаан жилийн тунадасны хэмжээ нэмэгдэх болсон нөхцөл нь 2018 оны 7, 8 дугаар саруудад болон 2021 оны 8 дугаар сард хур борооны эрчимшил маш их байсантай холбоотой байна.


Хур тунадасны хуваарилалт жилийн дотор харилцан адилгүй хуваарилагддаг. Хур тунадасны 89% орчим нь жилийн дулаан улиралд /VI-X сард/ үүнээс зөвхөн 7, 8 дугаар сард 65% нь орж байна. Өвөл, хавар орох хур тунадасны хэмжээ 0.4-10.1 мм-ээр буурсан байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дулааны улиралд орох хур борооны эрчим нэмэгдэж аадар, түр зуурын ширүүн усархаг бороо орж байгаа нь ажиглагдаж байна.

Энэ хирээрээ хөрсөнд шингэх чийг хангамж багасаж, сүүлийн жилүүдэд өвлийн хур тунадасыг оруулах нөхцөлийг хүндрүүлж харын зуд болоод байна.




Зураг 6. Хур тунадасны жилийн явц, мм-р болон жилд эзлэх хувь

Жилийн нийлбэр хур тунадасны сүүлийн зургаан жилийн явцыг харахад 2.34 мм-ээр бага зэрэг нэмэгдсэн үзүүлэлт ажиглагдаж байна. Ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд дулааны улиралд орох борооны эрчимшил өөрчлөгдөж богино хугацааны усархаг аадар бороо орох нь ихсэх хандлагатай байна.



Зураг 7. Жилийн нийлбэр тунадасны хуваарилалт, өөрчлөлтийн хандлага

Салхины горим: Ханбогд сумын салхины жилийн дундаж хурд 4.5 м/с буюу салхины хурд ихтэй байдаг бөгөөд олон жилийн өөрчлөлтийн хандлагыг харахад салхины хурд ялимгүй нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.



Зураг 8. Салхины дундаж хурдны явц

Шороон шуурга нь салхины хурд, хөрсний гадаргын байдлаас болж үүснэ. Хөрсний гадарга сул элс шороо багатай бол салхины хүч их байсан ч шороон шуурга шуурах нь бага харин хөрс нь хуурай элс, элс шороо ихтэй бол салхины хурд 8-9 м/с байх үед ч шороо босч шороон шуурга ажиглагддаг.

Шороон шуурга олонтаа тохиолдох нь мал бэлчээрлэлт саатах, хот суурин, зам харгуй элсэнд дарагдах зэргээр ард түмний аж амьдрал, аж ахуйн салбарын үйл ажиллагаанд ихээхэн сөрөг үр дагавар үзүүлдэг бөгөөд байгалийн гамшгийн хэмжээнд хүрч хөрс эдэгдэх, элсний нүүлт явагдах нэг шалтгаан болж байна. Шороон шуургатай өдрийн тооны жилийн явцыг авч үзвэл 3-6-р саруудад тохиолдлын тоо их байна.

2.4. АГААРЫН ЧАНАР

“Пүшинмон” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжүүлж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн орчимд агаар дахь тоосжилт, агаарын чанарын индекс болон дуу чимээний түвшинг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ.

Дээрх хэмжилт судалгаанд агаарын тоосжилт, чанарыг Temtop LK6-1000, дуу чимээг MS6300 Environment Multimeter багажуудыг ашигласан болно.

Хүснэгт 5. Агаарын чанарын хэмжилтийн дүн

№	Байршил	AQI	PM 2.5 (ug/m ³)	PM10 (ug/m ³)	HCHO (mg/m ³)	TVQC (mg/m ³)	Байршил
1	1-р цэг	33	8.0	12.2	0.01	0.04	Төслийн талбайд

Төслийн талбайд хийсэн хэмжилтийн дүнгээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17 -ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан Агаарын чанарын индексийн дүн, агаарын чанарын ангилалаар цэвэр, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд байна.

Төслийн талбайн орчимд хийж гүйцэтгэсэн тоосжилтын хэмжилт:
Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад PM10-12.2 мкг/м³, PM2.5-8.0 мкг/м³ утгатай гарч байв. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016-д PM10-100 мкг/м³, PM2.5-50 мкг/м³ байна гэж заасан бөгөөд эдгээр утгаас бага гарч байв.

Төслийн талбайд нүүрс тээвэрлэх, ачиж буулгах ажил түр зогссон, хөл хөдөлгөөн бага байсан нь тоосжилт бага, бусад агаар бохирдуулагчид бага буюу орчны агаар нь цэвэр байна.




Зураг 9. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийсэн байдал

2.5. ГАДАРГЫН УС

Өмнөговь аймаг нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагшаа урсацгүй ай савын бүсэд багтдаг.

Ханбогд сумын нутаг дэвсгэр нь бүхэлдээ Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарагдана. 2020 оны усны тоо бүртгэлээр Галба-Өөш-Долоодын говийн сав газарт нийтдээ 32 булаг, 86 нуур, тойром, 182 худаг бүртгэгдсэн байна.

“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн талбайн орчимд задгай урсах гол горхи, булаг шанд байхгүй, түр зуурын усны үйл ажиллагаагаар үүссэн гуу жалга хуурай сайр зэрэг үүссэн байдаг.



Зураг 10. Төслийн талбай орчмын усны сав газар болон гадаргын усны тархацын зураг

Усан хангамж: Төсөл хэрэгжүүлэгч нь ундны усыг савлагаатай цэвэр усаар хангадаг бол тоосжилтыг бууруулах болон бусад усыг төслийн талбайгаас 21.7 км - ийн зайд /42°46'56.00"N-107°24'12.00"E/ байрлах Иргэн Б.Баярцэнгэлийн эзэмшлийн 2.4 л/с ундаргатай гүний худгийн уснаас зөөвөрлөн авч, 2 тн цэвэр усны нөөцийн саванд түр хадгалан ашиглаж байна.

2.6. ГАЗРЫН ДООРХ УС

Өмнөговь аймагт анх 1961 онд Ю.М.Логинов 1:1000 000-ны масштабтай геологи-гидрогеологийн зургийг зохиосон ба мөн 1:500 000-ны масштабтай геологи-гидрогеологийн судалгааны ажлыг хийжээ.

Үүнээс хойш Даланзадгадын районд гидрогеологийн судалгаа нилээдгүй их хийгдсэн байдаг ба энэ нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод хүн ам ихээр төвлөрсөнтэй холбоотой юм.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтдээ 30 гаруй газрын доорх усны орд илрүүлсэн байдаг. Одоогоор уул уурхайн томоохон олборлолт явуулж буй, ирээдүйд баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, том хот суурин байгуулагдах газар нутгийн усны нийт нөөцийг судлан тогтоожээ.

- Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайт нүүрсний уурхай орчмын газар доорх усны нийт нөөц 8514 м³/хоног.
- Даланзадгад, Цогтцэций сумын ойр орчим, Тавантолгой нүүрсний ордын ойролцоох усны нийт нөөц 17611.32 м³/хоног.

- Баян-Овоо, Ханбогд сумын ойр орчим, Оюутолгой зэсийн ордын ойролцоох усны нийт нөөц 107135 м³/хоног байна.

Гүний усны хувьд энэ бүс нутагт Цавчир элс, Хар заг, Гүний хоолой, Галтын заг, Тэсэгний зоо гэх газруудад Палеогений сэвсгэр хурдас дахь уст үе, цогцолбор (E_{2ez}), Мезозойн тунамал хурдас дахь уст үе, цогцолбор (sMZ) тогтоогдсон байна.

Палеогены сэвсгэр хурдас дахь уст үе, цогцолбор (E_{2ez}). Уг хурдас нь нуур, нуур-голын гаралтай, голчлон улаан өнгийн шавар элснээс тогтох бөгөөд доод хэсэгтээ бүдүүн ширхэг элс, муу барьцалдсан конгомератын үеэнцэртэй, төмрийн усан ислээр будагдсан элсжин, гравелитийн үеүдтэй элсжин, дээд хэсэгтээ бор-саарал өнгөтэй бүдүүн ширхэгт элсжин, бор өнгөтэй мергелийн конкрец бүхий ягаавтар-шар өнгөтэй элснээс тогтоно. Энэхүү уст цогцолборын газрын доорх усны байгалийн баялаг нь хур тунадасны усны нэвчилтээс нөхөн сэлбэгдэх нөхцөл маш муутай бөгөөд региональ тэжээгдлийн гадаад мужаас ирэх газрын доорх усны урсацаар тодорхой хэмжээгээр тэжээгдэнэ. Энэхүү уст давхаргын ус ихэвчлэн Натри-Кальцийн бүлэг, гидрокарбонат-хлоритын ангийн найрлагатай байдаг.

Мезозойн тунамал хурдас дахь уст үе, цогцолбор (sMZ). Ус агуулагч хурдас нь ерөнхийдөө саарал, цайвар саарал, алаг өнгө зонхилсон элсжин, гравелит, конгломерат, цагаан саарал өнгийн элс, элсжин, улаан өнгийн элсэрхэг шавраас тогтох бөгөөд тулгуур зүсэлтийнхээ доод хэсэгт мергелийн конкрец, мергель, жижиг хайргат конгломерат, гравелит, шохойжингийн нарийн үе, мишэл агуулсан улаан, улаан-хүрэн, улаан шаргал, цайвар ногоон өнгөтэй шавар, элсжин зонхилно. Уг уст цогцолбор нь тархалт ихтэй бөгөөд томоохон ус хэрэглэгч болох төв суурин газар, уурхай, үйлдвэрлэлийн унд ахуйн болон техникийн хэрэгцээний усны нөөцийг хангах боломжтой.

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хөрсний хэв шинж: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад орчмын нутаг орчмын нутаг дэвсгэрт Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөргийн бүсшлийн цөлийн бор саарал хөрс, тэдгээрийн төрлүүд голлон тархсан байдаг.


Галбын говийн хөрсний тойрогт багтана. Энэхүү тойрогт нам уулс, толгодын хэсгээр эх чулуулгийн илэрцтэй, дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал (гөлтгөнөгүй), тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараалаг хөрс, элсэн хөрс голлон тархана.

Тухайн нутаг дэвсгэрт цөлийн бор саарал хөрсний төрөлд багтах дараах төрлийн хөрс тархана. Үүнд.

- Сайр чулуурхаг нимгэн цөлийн бор саарал
- Цөлийн бор саарал
- Элсэн хучаастай нугархаг, цөлийн бор саарал гэсэн хөрсний төрлүүд голлон тархсан байна.

Хүснэгт 6. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Цөлийн бор саарал хөрс		
	Сайр чулуурхаг нимгэн цөлийн бор саарал	5.6	14
	Цөлийн бор саарал	7.6	19
	Элсэн хучаастай нугархаг, цөлийн бор саарал хөрс	26.8	67
	Нийт	40.0	100



Зураг 11. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг

Хөрсний дээжийн лабораторийн задлан шинжилгээний дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд

Гүн см	pH	Давс %	EC ₂₅ Ds/m	Ялзмаг %	CaCO ₃ %	NO ₃ мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент мг/100	
							Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Дээж-1										
40-60	8.48	0.333	0.916	1.06	1.92	1.34	3	9	4.1	15
Дээж-2										
0-20	8.74	0.187	0.515	0.83	0.16	0.59	3	3	4.3	23
20-40	8.30	0.266	0.732	1.24	1.6	0.87	27	16	4.1	7
40-60	8.74	0.420	1.154	1.94	1.44	2.08	2	9	3.1	10

Хүснэгт 8. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
1	20-40	36.3	15.4	0.0	28.2	16.5	21.4
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1,5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

Хөрсөн дэх кадми элемент илрээгүй, цайр, хром, зэс, никель, хар тугалга гэх мэт хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс бага гарсан учир хөрс бохирдолгүй гэж үзлээ.

2.8. УРГАМЛАН НӨМРӨГ

Өмнөговь аймгийн нутаг нь Монгол орны байгалийн үндсэн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээр (говь), цөлийн бүсэд хамаардаг. Ургамал газар зүйн мужлалаар Олон нуурын хөндийн цөлөрхөг хээр, Дорнод говийн цөлөрхөг хээр, Алашаа говийн цөлийн, Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алтайн өвөр говийн (цөлийн) тойрог гэсэн 5 тойрогт хамрагдана. (А.А.Юнатов. 1946, 1950, А.М.Мурзаев. 1952, В.И.Грубов. 1955, Н.Өлзийхутаг. 1989).

Ханбогд сумын нутгийн хойд хэсэг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог, Улсын хил дагуух өмнөд хил нь Алашаа говийн цөлийн тойрогт тус тус хамрагдана.

Ханбогд суманд хамгийн их тархсан ургамлын бүлгэмдэл нь улаан бударгана, хулан хойрго оролцсон бор бударгана, бор бударгана-баглуурт (33.0%) бударгана, хялгана оролцсон баглуурт (15.7%) таана, шарилж, алтан харгана оролцсон хялгана-боролзот, боролз-хялганат (11.3%), хялгана-таанат, хялгана-таана-баглуурт (8.9%), баглуурт, баглуур-бударганат (4.2%), бударгана, баглуур оролцсон намхан ургасан заг (4.1%), улаан бударгана, бударгана оролцсон намхан ургасан заг (3.7%), өндөр ургасан заган ойн (3.2%) бүлгэмдлүүд нийт нутаг дэвсгэрийн 85 хувийг эзэлж байна.

Ханбогд сумын Цагаан хад орчимд шарилж-баглуурт, шарилж-баглуур-бударганат хэв шинжийн бүлгэмдлүүд зонхилж байна. Түгээмэл тохиолдох ургамлууд нь навчгүй баглуур-*anabasis aphylla L*, бор бударгана-*salsola passerina Bunge*, божмог шарилж-*artemisia anethifolia web ex Stechm*, шүлхий шарилж-*artemisia pectinata pall*, ямаан шарилж-*artemisia scoporia Woldst* юм.


“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн орчимд Чулуурхаг баглуурт, баглуур-бударганат бүлгэмдэлийн ургамал зонхилон тархана.

Тухайн төслийн талбайн орчны газарт зонхилгогч ургамлууд болох баглуур-бударганат ургамлын бүлгэмдэл үндсэндээ устсан, нэлэнхүйдээ халцгай, барилга байгууламж, хад чулууны ёроол хавиар ургамалтай боловч дан шарилж, хааяа хэсэгхэн газар баглуур, бударгана цөөн тохиолдоно.

Хүснэгт 9. Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал

Ургамлын бүлгэмдэл	Төлөв байдал	Талхлагдлын зэрэг
Чулуурхаг баглуурт, баглуур-бударганат	Бага сөөгтэй	Дунд зэрэг

Ихэвчлэн навчгүй баглуур-anabasis aphylla L, бор бударгана-salsola passerina Bunge, божмог шарилж-artemisia anethifolia Web ex Stechm, шүлхий шарилж-artemisia rectinata Pall, ямаан шарилж-artemisia scororia тааралдана.



Зураг 12. Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөгийн хэв шинж

2.9. АМЬТНЫ АЙМАГ

Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг

Ханбогд сум нь Өмнөговь аймгийн газар нутгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлалын ангилалаар Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)-т хамаарч байна.

Дорнод говийн цөлөрхөг мужид нийтдээ 4 ангийн 131 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 20.1% нь оршин амьдардаг байна.

Энэ мужид 5 баг, 11 овогт хамаарах 44 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 31.6% болно.

Дэлэнтний дийлэнх хэсгийг мэрэгчтэний багийн амьтад эзлэх бөгөөд (23 зүйл буюу энэ мужийн дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 52.2%) үндсэндээ Төв Азийн цөл, хээрийн гаралтай амьтаас бүрдэнэ. Зүйлийн бүрэлдэхүүний хувьд Алтайн өвөр говийн тойргийн дэлэнтэн амьтдынхтай төстэй.

Олон улсын ба Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан юмуу Улаан номонд орсон амьтаас цоохор ирвэс, эрээн хүрэн, хар сүүлт, янгир ямаа, аргаль хонь зэрэг 5 зүйл энэ мужийн нутаг дэвсгэрт амьдарна.

Дорнод говийн цөлөрхөг муж бол цагаан зээрийн нэг үндсэн тархац нутаг юм. Судалгааны дүнгээс үзвэл Дорноговь аймгийн Хатанбулаг чиглэлд 2037 км замлалд 23340 цагаан зээр тоолж 1 км-д 11.4 толгой, Алтанширээ чиглэлд 1750 км замлалд 16676 цагаан зээр тоолж, 1 км-д дунджаар 10.45 толгой цагаан зээр ноогдох нягтшилтай байна.

Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 10 баг, 22 овгийн 76 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ (36 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 47.3%).

Энэ мужид шонхор хэлбэртний багаас 11 зүйл (14.4%), хөгчүү хэлбэртний багийн 19 зүйл (25.0%) тус тус оршин амьдарна. Ус намгийн амьдралтай шувууд тун ховор.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орсон 14 зүйл шувуу (сохор элээ, морин харцгай, шилийн сар, тарважи бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, начин шонхор, хилэн жигүүрт, шар шувуу, хотны бүгээхэй, хулан жороо) тус мужийн нутаг дэвсгэрт бүртгэжээ.

Мөлхөгчидөөс энэ мужид 1 баг, 5 овгийн 10 зүйл тэмдэглэжээ. Улаан номон орсон нарийн могойноос бусад зүйл нь түгээмэл тархалттай, элбэг тохиолдох амьтад юм.

Хоёр нутагтанаас зөвхөн монгол бах тэмдэглэгдсэн ба тоо толгойн хувьд хэвийн хангалттай байна.

Төслийн талбайн амьтны аймаг


“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн ойр орчим буюу Цагаан хад суурьшлын бүсийн орчимд олон жил нүүрс тээврийн үйл ажиллагаа явагдаж, барилга байгууламж, бүтээн байгуулалтууд өрнөж байгаа тул ямар нэгэн ан амьтдын тархац байхгүй байна.

2.10. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ

Өмнөговь аймагт улсын тусгай хамгаалалттай газар дөрөв бий. Үүнд, Говийн Бага дархан цаазат газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Тост тосон бумбын нурууны байгалийн нөөц газар, Загийн усны тусгай хамгаалалттай газар багтдаг.

Харин 2023 онд шинээр Дэмчогийн хийд, Загийн тойром, Балгасын улаан нуур, Говь гурван сайханы ойролцоох газруудыг улсын тусгай хамгаалалтад авахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас төлөвлөсөн.

Ханбогд сумын нутагт Говийн Бага дархан цаазат газарын “Б” хэсэг хамаарагдах бөгөөд төслийн талбай нь Говийн бага дархан цаазат газрын “Б” хэсгээс 2.8 км зайд, Цагаан хад орчны бүсэд багтаж байна.




*Зураг 13. Төсөл хэрэгжих талбайн орчмын
Улсын тусгай хамгаалалттай газар нутаг*

Говийн Бага дархан цаазат газар: Монголын зүүн өмнөд говийн үндсэн хэв шинжийг төлөөлсөн, байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан, дэлхийд ховордсон амьтад болох хулан, хар сүүлтийн гол байршил нутаг бөгөөд Монголын жинхэнэ говийн байгалийн иж бүрдэл, ландшафтын өвөрмөц төрхийг хамгаалах зорилгоор нь УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор Говийн Бага дархан цаазат газар байгуулагджээ.

Энэхүү дархан цаазат газар нь А, Б гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нийтдээ 1.8 сая га талбай эзэлдэг. Өмнөговь аймгийн Номгон, Баян Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт оршино.


Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих талбай нь “Аймгийн урд талын сумдын улсын хил дагуу Ханбогд” нэртэй Аймгийн ОНТХГН-тай давхцалтай, “Галбын говь” /Сумын/ ОНТХГН-аас 11.11 км, “Дайчингийн говь, Хонгорын овоо, Оройн худгийн зоо” нэртэй /Сумын/ ОНТХГН -аас 13.1 км-ийн зайд оршиж байна.



*Зураг 14. Төсөл хэрэгжих талбай орчмын
Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг*

2.11. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг нь Агуйтын хийдийн туурь, Байшин цавын палеонтологийн дурсгалт газар, Баянхөөвөрийн хүн чулуун хөшөө, Далайн дуулга уулын хадны зураг, Дэмчигийн хийд, Жавхлант хайрханы хадны зураг, Зүрх уулын чулуу олборлож байсан газар, Зүүн хацавчийн хадны зураг, Мангасын хүрээ хэмээх эртний хэрэм, Үрэлбэгийн палеонтологийн дурсгалт газар, Хуурай цавын палеонтологийн дурсгалт газар, Хүрдэт агуйн бичээс, Цогцолын хийд, Шийр хайрханы хадны зураг зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудтай.



Зураг 15. Ханбогд сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын байршил

“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн талбай байрлах Цагаан хад суурьшлын бүстэй хамгийн ойр байрлах түүх, соёлын дурсгал нь Гурван зээрдийн агуй, Мангасын хүрээ хэмээх эртний хэрэм байна. Төслийн талбай нь дээрх түүх, соёлын дурсгалт газруудаас хол байрших тул ямар нэгэн шууд нөлөөлөл байхгүй болно.

Мангасын хүрээ хэмээх эртний хэрэм: Сумын төвөөс зүүн өмнө зүгт 75 орчим км зайд 135x140 м хэмжээтэй дөрвөлжин шороон далантай, түүний гадуур 600 м хэмжээтэй дугуй далан бүхий эртний хэрмийн үлдэгдэл бий. Энэ очимоос төмөр шилбэт хүрэл зэв, ширмэн сүх, ваар савны хагархай зэрэг олддог бөгөөд судлаачид Хүннү гүрний үед хамаарна хэмээн үздэг байна.

2.12. Нийгэм, эдийн засаг

Ханбогд сум нь 1924 онд Галба сум нэртэйгээр Хадан хошуу гэх газарт анх үүсгэн байгуулагдсан түүхтэй. Үүнээс хойш олон удаа нүүдэллэж 1941 онд одоогийн Их булаг хэмээх газарт суурьшжээ. Ханбогд сум Цаг уурын хувьд зундаа +40 хэм хүртэл халж, өвөлдөө -15-25 хэм хүрч хүйтэрдэг байгалын эрс тэс уур амьсгалтай. Монгол Улсын хамгийн дулаан цэгт тооцогддог газар нутаг юм.

Сумын хэмжээнд Сумын ЗДТГ, ИТХ, Эрүүл мэндийн төв, Нийгмийн даатгалын хэлтэс, 21, 22, 29, 32-р цэцэрлэг, 1-р сургууль, 2-р сургууль, “Үлэмжийн чанар” соёлын төв, Ханбогд хот тохижилт, Хандизель, Оргилдорж ШҮГ зэрэг ОНӨААТҮГ, орчин үеийн иж бүрэн лаборатори бүхий сум дундын Малын эрүүл мэндийн төв, Цаг-Уурын өртөө, Говийн Бага Дархан Цаазат Газрын Хамгаалалтын Захиргаа, Цагдаагийн тасаг, Сум дундын шүүх, Сум дундын прокурор, ШШГХ, ГБДЦГХЗ, Гал

түймэр унтраах аврах 66-р анги, сумын Залуучуудын Хөгжлийн Төв, Ханбогд сумын Насан туршийн боловсрол нэгж, хувийн хэвшлийн 2 эмийн сан, Хаан банк, Хас банк, Төрийн банк, Голомт банк, Капитрон банк зэрэг 5 банк, Петровис, Тэс Петролиум, Дашваанжил, Петролайн зэрэг 4 ШТС ажил үйлчилгээ явуулж байна.

2023 оны 1-р сарын байдлаар 8055 иргэн бүртгэлтэй байна. Ханбогд сум хөдөө аж ахуйн 5 багтай. Жавхлантаг багт 2301, Гавилууд багт 1889, Номгон багт 1304, Баян багт 2301, Хайрхан багт 426 иргэн тус тус бүртгэлтэй амьдарч байгаа бол үүнээс шилжин ирсэн 648, шинээр 125 хүүхэд мэндэлсэн байна. Малын тоо толгой 208328 толгойд хүргэсний дотроос улсдаа хамгийн олон тэмээн сүрэг буюу 34420, адуу 11407, үхэр 8403, хонь 58565, ямаа 95533 толгой мал тоологдож өмнөх онтой харьцуулахад адуу 1020 толгой (9.82%), үхэр 843 (11.15%), тэмээ 1331 толгой (4.02%), хонь 4290 (7.9%), ямаа 7940 (9.06%)-аар тус тус өссөн дүнтэй байна.

Газарзүйн байршлаар авч үзвэл Ханбогд сум нь Өмнөговь бүс нутгийн томоохон стратегийн ач холбогдол бүхий хөгжлийг тодорхойлох сум юм.

Сумын нутаг дэвсгэрт Оюутолгойн орд, түүнчлэн зүүн хойд талдаа Цагаан суваргын алт, зэсний орд, зүүн тийшээгээ Хармагтайн орд, хойд талдаа Цогт-Цэцийн Тавантолгойн уурхай гээд Монгол орны томоохон хөрөнгө оруулагч, төсөв санхүү бүрдүүлэгч уурхайнуудын яг гол, төв хэсэгт нь байрладаг.

Төсвийн 21 байгууллагад 468 төрийн албан хаагч, уул уурхайн салбарт 1710 иргэн, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр оёдолын салбарт 10 аж ахуй нэгж, хүнсний үйлдвэрлэлийн 9 салбар, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 ААН, барилгын 7 салбар, аж үйлдвэрийн 3 салбар, арьс шир оёдолын 2 ААН үйлдвэрлэл эрхэлж байна. Мал бүхий 724 өрхийн 2394 иргэн ажиллаж сум орон нутгийн хөгжилд хувь оруулж байна.

Мөн хүнсний дэлгүүр 23, бөөний төв 2, авто сервис дугуй засварын чиглэлээр 13, Зоогийн газар 8, зочид буудал 9, уул уурхай болон бусад чиглэлээр 683 ААН бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зөвхөн аж ахуйн нэгжид ажиллаж НДШ-ээ төлдөг ажилчдын тоо 6992 хүрсэн нь амжиргааны түвшин нэн таатай үзүүлэлттэй байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Улсын төсөвт 10,356,542,100 ₮, Орон нутгийн төсөвт 97,664,433,800 төгрөгний татвар төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ


3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл

“Пүшинмон” ХХК-ийн нүүрс ачиж буулгах, гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт улсын хилээс хойш 20 гаруй км-т Цагаан хадын худгаас баруун хойш 3.5 км–т 40 га газар байрлана.

Төсөл хэрэгжүүлэгчийн төлөвлөж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн орчимд хийсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хүрээн дэх судалгаагаар төслийн нөлөөллийг 2 бүсээр хуваан авч үзлээ.

Үүнд :

- Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 100, 200 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.



Зураг 16. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс

Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн эзэмшлийн талбайн ойр орчмын 200 м хүртлэх талбайд хяналт тавьж ажиллах шаардлагатай.

3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нөлөөлөл харьцангуй бага. Тус компанийн үйл ажиллагааны нөлөөгөөр 7.2 га талбай нөлөөлөлд өртсөн байдалтай байна.

- Гадаад дотоод тээвэрлэлт хийх автозам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас газрын гадаргад эвдрэл үүссэн.
- Төслийн талбайн хатуу хог хаягдлыг зайлуулах хогийн цэг, нүүрсний тоос, хаягдал, шатах тослох материалын хаягдлаас газрын гадаргуу бохирдож болзошгүй.

3.3. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагаанаас тухайн бүс нутгийн агаарын чанарт нөлөөлөх гол нөлөөллүүдэд төслийн хүрээнд явагдах үйл ажиллагаа болох нүүрс тээвэрлэлт, гаалийн буулгалт, ачилт хийх үеийн ажилтай холбоотойгоор агаарт босох тоос шороо, хүнд даацын машин механизмууд автомашины ялгарах хорт утаа зэрэг орох ба эдгээр нь төслийн нутаг дэвсгэрийн ойр орчмын агаарын чанарыг муутгаж, орчны тоосжилтыг ихэсгэх магадлалтай.

БОННУ-ний тайлангийн нэмэлт тодотголд дурдсанаар гаалийн талбайн үйл ажиллагаанаас ялгарах нийт тоосны тархалт стандартаас давах хэсгийн агууламж 269 мкг/м³ буюу стандартын хүлцэх хэмжээнээс 2.7 дахин, PM10 тоосонцрын агууламж 75 мкг/м³ буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ 50 мкг/м³ агууламжаас 1.5 дахин давж орчны агууламжийг нэмэгдүүлж байна. Төслөөс орчны агаарын чанарт нөлөөллөх бүсийн талбайн хэмжээ төслийн талбай болон тээврийн зам орчмын 323 га талбайг хамарч байна.

3.4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагааны явцад усан орчинд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй.

- Төсөл хэрэгжих явцад гүний худгаас зөврөөр ус авч ашиглах учир газрын доорх усны нөөцөд тодорхой хэмжээгээр шууд нөлөөлнө.
- Төслийн талбай, түүний орчим гол, горхи, булаг шанд, хаврын шар ус, хур борооны үерийн усаар тэжээгддэг хуурай сайр байхгүй учир гадаргын усны чанар болоод нөөцөд төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөл үзүүлэхгүй.
- Тээврийн хэрэгслээс дизель түлш алдагдах, ослын үед нефть бүтээгдэхүүнийг үлэмж их алдвал хөрс, хэвгий газраар дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбайд тархах Цөлийн бор саарал хөрс нь гадны нөлөөгөөр элэгдэлд маш хурдан орж үржил шимээ хурдан алддаг бөгөөд байгалийн аясаар дахин сэргэх нөхцөл туйлын хомс байдгийг эрдэмтэд тогтоосон байдаг. Төсөл хэрэгжих орчны хөрс нь байгалийн хүчин зүйлээс гадна тээврийн хэрэгслийн нөлөөгөөр олон салаа зам үүсч тэдгээрээс шалтгаалан үржил шим, унаган бүтцээ алдан салхинд хийсэх замаар элэгдэлд орсон байдал ажиглагдаж байна.

Хөрсөн бүрхэвчинд төслөөс дараах нөлөөллүүдийг үзүүлнэ. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн улмаас хөрс талхлагдах
- Барилга, байгууламжид өртөх
- Нүүрсний тоос, бүтэц нь алдагдсан үхмэл шороонд дарагдах гм.
- Техник машин механизмын түлш шатахуун, тос тосолгооны материал зэргийг алдаж асгаснаас хөрс бохирдох

3.6. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Тоосжилт нь ургамлын фотосинтезийн процесст саад учруулж өсөлт хөгжлийг зогсоох.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан тэр орчмын газар талхлагдалд өртөж ургамлан нөмрөг устах

Төсөл хэрэгжих явцад ашиглалтын талбайд нийтдээ 40 га талбайг ашиглах бөгөөд тээвэрлэлтийн явц, тоосжилтоос ургамал талхлагдалд орох, ургамлын аймгийн зүйлийн бүрдэл цөөрч үгүй болох, өөрчлөгдөх зэргээр тухайн газарт экосистемийн өөрчлөлт гарах сөрөг нөлөөтэй

3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Төслөөс тухайн орчны нийгэм, эдийн засагт дараах байдлаар нөлөөлнө.

- Төслийн талбайд оршин суугчид үгүй учир нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөхгүй, нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.
- Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 28 хүний ажлын байр бий болно.
- Төсөл хэрэгжих ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

БҮЛЭГ-4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
Нүүрс ачиж, буулгах, түр хадгалах үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдал, Тоосжилт	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулах	Тээврийн 24 автомашин	2 удаа	-	-	2024 оны 04 сард	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2015 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага MNS 5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 5973:2009 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ
	Төслийн талбайд ногоон байгууламж байгуулах, тарималжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх	Төслийн талбайд	4 га - гаас багагүй талбайд	-	-		
	Салхинаас хамгаалах 8 м өндөр хашааны хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогмол хийж байх	Салхинаас хамгаалах 10 м өндөр хашаа	-	-	Сард 2 удаа		
	Төв замаас төслийн талбай хүртэлх замыг хайрган хучилттай болгох	200 метр зам	1	650.0	5 сард		
	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийнэ.	Дотоод болон гадаад тээврийн зам	-	-	Тогтмол		
	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээг байршуулах)	Төслийн талбай болон гадна замд	6	100.0 x 6 = 600.0	4 сард		
	Замд гарсан эвдрэлийг богино хугацаанд засварлаж, машин техник саадгүй явах нөхцөлийг хангах	Төслийн талбай болон гадна замд	-	-	Тогтмол		
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний	28 ажилтан	-	-	Тогтмол		

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, Галлагаанд ашиглах нүүрс болон галлагаанаас гарах үнсийг салхинд хийсэхээс хамгаалах арга хэмжээ авч ажиллах	Ажилчдын сууринд	-	300.0		4 сард	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
Ус хэмнэх	Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж суурилуулах	Ажилчдын сууринд	ҮАЗ-д тусгах			5 сард	
Усны нөөцийн хомсдол үүсэхээс сэргийлэх	Хаягдал пластик сав ашиглан ногоон байгууламж услах дуслын усалгааны систем хийх	Төслийн талбайд	Ногоон байгууламжийн хэмжээнээс хамаарна.			4 сард	Усны тухай хууль “Хот суурин газарт ундны ус түгээх цэгийн үйлчилгээ.” ерөнхий шаардлага MNS 5775:2007 “Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт” MNS 0900:2018
Усны нөөц, хэрэглээ	Усыг хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээндээ ашиглах /ус хэмнэгч хошуу/	Ариун цэврийн өрөө, гал тогооны угаалтуурт	-	-		4 сард	
Ус хэмнэх	Борооны ус хуримтлуулах төхөөрөмж суурилуулах	Төслийн талбайд	Дотоод төлөвлөлтөөр			6 сард	
Ахуйн хаягдал, шатах, тослох материалын хаягдлаас бага гүний уст давхарга бохирдох	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авах, төлөвлөлт хэрэгжүүлэх	Төслийн талбайд	300.0			Тогтмол	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
Хөрсөнд шатах тослох материал алдагдах, хөрс бохирдох, тоосжилт	Төслийн талбай доторх, авто замыг хатуу /хайрган/ хучилттай болгох	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгах			Төсөл хэрэгжүүлэгч	Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007
	Явган хүний замыг зориулалтын хавтан суурилуулж засах	Төслийн талбайд	350.0			4 сард	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Галлагаанд ашиглах нүүрс болон галлагаанаас гарах үнсийг хөрс бохирдохоос хамгаалж, аль болох бага талбайд байрлуулах	Төслийн талбайд		-		4 сард	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2014
	Шатах тослох материалыг зориулалтын цэгт хадгалж орчныг бохирдуулахгүй байх, бохирдсон хөрсийг тухай бүрт нь саармагжуулах	Төслийн талбайд		-		4 – 12 сард	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
Олон салаа зам гарах өөрчлөгдөх	Тээврийн хэрэгслийг тогтсон замтай болгож, замын тэмдэг тэмдэгжүүлэлтийг стандартын дагуу хийж байршуулах	Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, агаар орчин		-		4 сард	
Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг Тогтмол		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Тогтмол	
Нийт зардал				2 200.0			

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. “Гаалийн хяналтын талбай”-н ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах ажлыг БОННУ-ний тайлан тусгасан зөвлөмжийн дагуу тарих шаардлагатай. Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Жил

бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байна.

Хүснэгт 11. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Төслийн талбайг тохижилтын дагуу мод бут тарьж хашаалах	Жигд, сухай, хайлаасны тарьц	Төслийн талбай	ш	50	15.0	750.0	2024 онд 5,10 сард
2		Суулгацыг суулгах		удаа				
3	Мод, бутны арчлалт хамгаалалт	Ургаагүй мод бутыг нөхөн тарих арчлалт хамгаалалт хийх		удаа	-	-	-	Тогтмол
	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох		Цагаан хад сууринд болон зам дагуу сум орон нутгийн захиргааны заасан газарт	ш	100	15.0	1 500.0	2024 он
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг						2 250.0		

4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанд ахуйн угаалгын (саван, шампунь, угаалгын нунтаг) бодисоос өөр химийн болон цацраг идэвхт бодис хэрэглэгдэхгүй. Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай.	Галын аюулгүй байдлын дүгнэлт болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг аймгийн онцгой байдлын газраар батлуулан мөрдөн ажиллах	-	2024.04 сард
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод журам	2024.04 сард
	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	500.0	2024.05 сард
	Гал түймрийг хамгаалах хэрэгслийг төслийн талбайд байршуулах	Гал унтраагуур /3 кг/ - 35.0 х 10 ш = 350.0 Галын самбар – 29.5 Анхны тусламжийн хайрцаг – 33.0 х 2 ш = 66.0 Нийт 445.5	2024.05 сард
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, төслийн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	500.0	2024 оны 04 сараас
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	-	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	-	2024 он
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - төслийн талбай дотор таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Үйл ажиллагааны зардал	Жил бүр, жилд 1 удаа
НИЙТ ЗАРДАЛ		1 445.5	

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын түр хадгалах цэгийг хашаа хамгаалалттай болгон эх үүсвэрээс нь эхлэн ангилан ялгалт хийж, дахин ашиглахгүй хаягдлыг нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаях	Төслийн талбайд	-	60.0 x 12 сар = 720.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн хүрээнд	-	-	3 сард нэг удаа	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төслийн хүрээнд	Хэрэглээний хэмжээгээр	-	-	
	Хог хаягдлын төлбөр хураамжийг тогтмол төлөх	Төслийн хүрээнд	-	Гэрээний дагуу төлөх	Сар бүр	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Төслийн ажилчид	-	-	Сар бүр	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	-	Үйл ажиллагааны зардалд	-	2024 оны 05 сард	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Эзэмшил газрын гадна орчмын 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Эзэмшил газрын гадна орчмын 50 метр хүртэлх талбайд	-	-	2024 онд тогтмол	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах /стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох/	Ажилчдын сууринд	-	3000.0	2024 оны 05 сард	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАЗардалд тусгах	2024 оны 04 сараас	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 5885:2016

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Үйл ажиллагааны явцад ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийлгэх	Ажилчдын суурин, хог хаягдал түр хадгалах цэгт	-	-	2024 оны 04 сараас тогтмол	-
НИЙТ ДҮН				3 720.0		

4.5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	-	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Төв замаас төслийн талбай хүртэлх замыг хайрган хучилттай болгох, засч сайжруулах	-	СНБАХТ-нд тусгав.	Төслийн хугацаанд	
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	28 хүн	Төсөв баталж хэрэгжүүлэх	2024 онд	
Төслийн талбайн автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох	Тээврийн хэрэгслийн зогсоол	Төсөв баталж хэрэгжүүлэх	2024 онд	
Галын аюулгүй байдлын дүгнэлтийг Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	Төслийн хүрээнд	-	2024 онд	
Нийт, мян.төг		-		

4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 15. Таван жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө


Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Үйл ажиллагааны зардлаар	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн тайлан	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр үр дүн, дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар	Компаний байранд
Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоо	Хэвлэмэл болон цахим тайлан		Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	Хариуцсан мэргэжилтэн	-	Сумын удирдлагын ордон
Хайрхан багийн ИНХ	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга		Жил бүрийн 10 сарын 25-ны дотор		-	Хайрхан багийн ИНХ-ын байранд
Нийт					-	

4.7. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын чанар							
Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM _{2.5} , PM ₁₀) шинжилгээ хийлгэж байх	Агаар-1 4718883.45 705121.88	7 сард	1	60.0	120.0	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 4585:2016 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ хэвийн норм, түвшиний хэмжээ
Дуу шуугиан, чичиргээний хэмжилт хийх	Агаар-2 4718703.58 705070.32	7 сард	1				
Хөрсөн бүрхэвч							
Хөрсний ерөнхий шинжилгээ	Хөрс-1 4718835.83 705087.49	7 сард	1	25.0	2 цэг х 2 дээж х 25.0 = 100.0	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”, MNS 5859:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”
Хөрсний бохирдлын шинжилгээ, хүнд металл	Хөрс-2 4718751.60 705136.42		1	25.0	2 цэг х 1 дээж х 25.0 = 50.0		
Ургамлан нөмрөг							
Ургамлан нөмрөгийн бичиглэл хийх	Ургамал-1 4718883.45 705121.88	7 сард	2	-	-	Мэргэжлийн байгууллага, шинжээчээр хийлгэх	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх 5 жилийн гүйцэтгэлийн зардал					270.0		

Тус төслийг хэрэгжүүлэх 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **9 885.0** мян.төгрөгийг төлөвлөж өглөө.



Зураг 17. ОХШХ хэрэгжүүлэх цэгийн байршлын зураг

